ДОРНОД АЙМГИЙН “ЧУЛУУНХОРООТ” СУМЫН СУРГУУЛИЙН

3 ДУГААР АНГИЙН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ СЭДЭВ

А ХУВИЛБАР

3 ... ангийн сурагч .....

60 МИНУТ **18 ОНОО**

НЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

САНАМЖ: 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

МОНГОЛ ХЭЛ

Ээжийн цамц

Нэгэн өдөр Сувдаа охины ээж ажил ихтэй байсан болохоор цамцаа угааж чадалгүй ажилдаа явсан байв. Тэр цамц ээжийнх нь хувцасны дотроос хамгийн гоёмсог нь байлаа. Сувдаа ээждээ туслахаар цамцыг угаав. Угаалгын машин дотор хийн угааж, хэцэн дээр тохлоо. Оройхон цамцаа үзтэл дүүд нь таарахаар жижиг болсон байв. Ээж нь удахгүй ажлаасаа ирнэ. Сувдаа охин сандран, цамцыг авч индүүдэн сунгаж татсан боловч том болсонгүй. Хаалга тогшив. Тэр ээжээсээ айгаад цамцыг нууж орхижээ.

1. 1 Сувдаа охин ямар буруу үйлдэл хийсэн бэ? \1 оноо\

А. Ээжийнхээ гоёмсог цамцыг угаасан
Б. Угаалгын машинаар угаасан
В. Цамцыг авч индүүдэн сунгаж татсан
Г. Цамцыг зааврын дагуу зөв угаагүй

1.2 Сувдаа охины зан чанарт тохирох үгийг дугуйлаарай. \1 оноо\

А. тусч Б. залхуу в. шударга г. харамч

1.3 Асуух үгэнд хариулагдах үгсийг олоорой. \1 оноо\

Хэн? ээждээ туслахаар **юуг?** угаав.

А. Охин, өмдийг Б. Ээж, индүүг В. Сувдаа, цамцыг Г. Дүү, угаалгын машиныг

1.4 Зөв бичсэн үгийг олж дугуйл. \1 оноо\

А. чанрын Б. өгөхөөр В. багшыг Г. болхоор

2.1 Эсрэг утгатай үгийг олъё. \2 оноо\

Өдрийн бодол, ...зүүд

Хал нь гаднаа, хайр нь.....

2.2 Сувдаа охинд хандан талархлын захидал бичээрэй. \3 оноо\

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

МАТЕМАТИК

САНАМЖ: 1. Зааврыг сайтар уншаад гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

1. “ Зургаан мянга долоон зуун тав”-г стандарт хэлбэрээр бичээрэй. \1 оноо\

   А. 6725 Б. 6805 В.6705 Г. 6715

2. Дараах дүрсүүдээс аль нь мохоо өнцөг вэ?

А. Б. В. Г.

3. Аль жагсаалт нь хамгийн багаас хамгийн их рүү эрэмбэлэгдсэн болохыг олж, өмнөх үсгийг дугуйлаарай.

   А. 6502, 6590, 6529, 6592 Б. 6502, 6529, 6590, 6592

   В. 6592, 6590, 6529, 6502 Г. 6502, 6592, 6529, 6590

4. Сурагчдын түүсэн жимсний хэмжээг зургаар дүрслэн үзүүлэв.

3 дугаар анги	
4 дүгээр анги	
5 дугаар анги	

нь 6 кг жимс, нь 3 кг жимсийг тус тус төлөөлнө.

Сурагчид бүгд хэчнээн килограмм жимс түүсэн бэ?

А. 9 кг Б.48 кг В. 54 кг Г.60 кг

5. Заасан нэгжид шилжүүлээрэй.

А. 3 км 250 м = (3 х . . . .) м + 250 м = ...м

6. Сурагчдын нэгдүгээр улиралд уншсан номын тоог хүснэгтэд үзүүлэв.

	Амар	Болд	Туяа	Чимгээ	Янжин
Уншсан номын тоо	5	7	6	8	7

А. Сурагчдын уншсан номын тоог баганан диаграммаар дүрслээрэй.

Б. Хэн хамгийн олон ном уншсан бэ?

. . . . . .

В. Амар Янжингаас хэдээр цөөн ном уншсан бэ?

. . . . . .

ДОРНОД АЙМГИЙН “ЧУЛУУНХОРООТ” СУМЫН СУРГУУЛИЙН

3 ДУГААР АНГИЙН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ СЭДЭВ

3 ... ангийн сурагч .....

Б ХУВИЛБАР

60 МИНУТ **18 ОНОО**

НЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

САНАМЖ: 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

МОНГОЛ ХЭЛ

Ээжийн цамц

Нэгэн өдөр Сувдаа охины ээж ажил ихтэй байсан болохоор цамцаа угааж чадалгүй ажилдаа явсан байв. Тэр цамц ээжийнх нь хувцасны дотроос хамгийн гоёмсог нь байлаа. Сувдаа ээждээ туслахаар цамцыг угаав. Угаалгын машин дотор хийн угааж, хэцэн дээр тохлоо. Оройхон цамцаа үзтэл дүүд нь таарахаар жижиг болсон байв. Ээж нь удахгүй ажлаасаа ирнэ. Сувдаа охин сандран, цамцыг авч индүүдэн сунгаж татсан боловч том болсонгүй. Хаалга тогшив. Тэр ээжээсээ айгаад цамцыг нууж орхижээ.

1. 1 Эхэд юуны тухай өгүүлж байна вэ? \1 оноо\

А. Ээжээсээ айсан охины тухай
Б. Ээжийн цамцны тухай
В. Хувцсаа зааврын дагуу зөв угаах тухай
Г. Цамцыг угаагаад, хатаасан тухай

1.4 Сувдаа охины зан чанарт тохирох үгийг дугуйлаарай. \1 оноо\

А. харамч Б. шударга в. залхуу г. тусч

1.5 Асуух үгэнд хариулагдах үгсийг олоорой. \1 оноо\

Ямар? цамцыг **хэн?** нь байнга өмсдөг.

А. Хиртэй, өмд Б. Цагаан, индүү В. Гоёмсог, ээж Г. Дүү, угаалгын машин

1.4 Зөв бичсэн үгийг олж дугуйл. \1 оноо\

А. үнрийн Б. авахаар В. багажыг Г. хэлхээр

2.2 Эсрэг утгатай үгийг олъё. \2 оноо\

Өдрийн бодол, ...зүүд

Могойн эрээн гаднаа, хүний эрээн .....

2.2 Сувдаа охинд хандан талархлын захидал бичээрэй. \3 оноо\

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

МАТЕМАТИК

САНАМЖ: 1. Зааврыг сайтар уншаад гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

1. Мянгын ангийн гурван нэгж, нэгжийн ангийн зургаан нэгжээс бүтсэн тоо аль нь вэ? \1оноо\
   А. 36 Б. 306 В. 3006 Г. 30006

2. Тэгш өнцөгтэй дүрс аль вэ?

А. Б.  В. Г. 

3. Аль жагсаалт нь хамгийн ихээс хамгийн бага рүү эрэмбэлэгдсэн болохыг олж, өмнөх үсгийг дугуйлаарай. \1 оноо\

А. 6502, 6590, 6529, 6592 Б. 6502, 6529, 6590, 6592

В. 6592, 6590, 6529, 6502 Г. 6502, 6592, 6529, 6590

4. Сурагчдын тарьсан модны тоог хүснэгтээр харуулав. Очир хэдэн мод тарьсан бэ?



А. 7 Б. 40 В. 70 Г. 35

5. Заасан нэгжид шилжүүлээрэй. \2 оноо\

А. 4 км 350 м = (4 х . . . .) м + 250 м = ...м

6. Сурагчдын нэгдүгээр улиралд уншсан номын тоог хүснэгтэд үзүүлэв. \3 оноо\

	Бат	Баяр	Тамир	Болор	Саран
Уншсан номын тоо	6	5	3	4	7

А. Сурагчдын уншсан номын тоог баганан диаграммаар дүрслээрэй.

Б. Хэн хамгийн олон ном уншсан бэ?

. . . . . .

В. Бат Сарангаас хэдээр цөөн ном уншсан бэ?

. . . . . .